



**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

14201 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 2а,
Утас: 32-01-26, Факс: (976-11) 31-93-35,
E-mail: info@erc.mn

2020. 08. 04 № 1/996
танай _____-ны № _____-т

ЦАХИЛГААН ТҮГЭЭХ,
ЦАХИЛГААНААР
ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАНГАХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ
КОМПАНИУДАД

Тогтоол мөрдөж ажиллах тухай

Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 404, 405, 406 дугаар тогтоолоор Төв, Зүүн, Өмнөд, Баруун, Алтай-Улиастай бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон цахилгаан тэжээлт автомашин цэнэглэгч станцад борлуулах цахилгааны тарифыг баталсан.

Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгэгдэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж цахилгаан цэнэглэгч станцын цахилгаан тэжээлт автомашинд худалдах үнэ тарифт хяналт тавьж, цахилгаан тэжээлт автомашин цэнэглэгч станцад олгосон техникийн нөхцөл, цахилгаанаар хангах гэрээний биелэлтийг Эрчим хүчний зохицуулах хороонд тайлагнаж ажиллахыг үүгээр мэдэгдэж байна.

Жич: Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2020 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 404, 405, 406 дугаар тогтоолуудыг хавсралтаар хүргүүлэв.



А.ТЛЕЙХАН



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Б.Ширэндавийн гудамж 8/4, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, И-мэйл: foreign@mofha.gov.mn,
Вэбсайт: www.mofha.gov.mn

2020.07.27 № 1-1/130
танай 2020.07.09 -ны № 4/931 -т

Улсын нэгдсэн бүртгэлд
бүртгэсэн тухай

Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2020 оны 383, 384, 403, 404, 405, 406 дугаар тогтоолуудыг Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хуулийн дагуу хянан үзэж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэснийг мэдэгдье. Үүнд:

1. "Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф батлах тухай" 2020 оны 383 дугаар тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4838 дугаарт;

2. "Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хэрэглэгчдэд борлуулах хэрэгцээний халуун ус халаасан дулааны тариф батлах тухай" 2020 оны 384 дүгээр тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4839 дугаарт;

3. "Нарийн сухайт эрчим" ХХК-иас хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тариф батлах тухай" 2020 оны 403 дугаар тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4840 дугаарт;

4. "Төв, Зүүн, Өмнөд бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон цахилгаан тэжээлт автомашин цэнэглэгч станцад борлуулах цахилгааны тариф батлах тухай" 2020 оны 404 дүгээр тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4841 дугаарт;

5. "Баруун, Алтай-Улиастай бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон цахилгаан тэжээлт автомашин цэнэглэгч станцад борлуулах цахилгааны тариф батлах тухай" 2020 оны 405 дугаар тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4842 дугаарт;

6. "Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам"-ын цахилгаан тэжээлт автомашин цэнэглэгч станцад борлуулах цахилгааны тариф батлах тухай" 2020 оны 406 дугаар тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4843 дугаарт.



Х.НЯМБААТАР



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2020 оны 07 сарын 27-ны
өдрийн У.У./дугаарт бүртгэв.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 404

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2, 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Төв, Зүүн, Өмнөд бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон цахилгаан тэжээлт автомашин цэнэглэгч станцад борлуулах цахилгааны тарифыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн цахилгаан тэжээлт автомашин цэнэглэгч станцад олгосон техникийн нөхцөл, цахилгаанаар хангах гэрээний хэрэгжилтэд Аймаг, Нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөл хяналт тавьж ажиллахыг даалгасугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Г.Эрхэмбаяр/-нд даалгасугай.

ДАРГА

А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

Б.БАТТУЛГА


ЗОХИЦУУЛАГЧ

У.МЯГМАРСҮРЭН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.САМДАН

Эрчим хүчний зохицуулах хорооны
2020 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн
404 дүгээр тогтоолын хавсралт



ЦАХИЛГААН ТЭЖЭЭЛТ АВТОМАШИН ЦЭНЭГЛЭГЧ СТАНЦАД БОРЛУУЛАХ ЦАХИЛГААНЫ ТАРИФ

1. Цахилгаан тэжээлт автомашин цэнэглэгч станцад борлуулах цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Энгийн тоолууртай	Төг/кВт.ц	155.90
2	3 тарифт тоолууртай		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 17.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	155.90
б	Оройн хэрэглээ /оройн 17.00 цагаас шөнийн 22.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	276.00
в	Шөнийн хэрэглээ /шөнийн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	77.10
3	Чадлын тариф	Төг/кВт/сар	9,000.00

Тайлбар:

- Өдөр, орой, шөнийн тарифыг мөрдөх хугацааг тоолуурын цагаар тооцно.
- Арилжааны болон хэрэглэгчдийг татаж ашиг, орлого олох зориулалт бүхий цахилгаан эрчим хүчээр цахилгаан тэжээлт автомашин цэнэглэгч станцад энэхүү тарифыг мөрдөнө.
- Хэрэглэгч 220 В хүртэл хүчдэлийн түвшинтэй 1-ээс дээшгүй цахилгаан тэжээлт автомашин цэнэглэгч төхөөрөмжийг суурилуулсан тохиолдолд цахилгаан эрчим хүчээр хангагчтай байгуулсан гэрээгээр зохицуулагдаж дээрх тарифыг мөрдөхгүй.